



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Буйр нуур – Мэнэнгийн талын сав газрын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2022/169/НА/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Чойбалсан хот

2022 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: И.Сэмжидмаа

Утас: 7058-4207, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Нармандах

Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn

Аудитор: Ч.Удвалноров

Утас: 7058-4207, Цахим хаяг: udvalnorovch@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
3. Аудитын тайлан	8
3.1 Ерөнхий зүйл	8
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	9
3.4 Материаллаг байдал	9
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	9
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	10
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	10
3.8 Аудитын гол асуудал	10
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	10
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	11
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	11
4. Аудитын илрүүлэлт	11
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	12

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
ДОА	Дорнод аймаг
НА	Нотлох аудит
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
Ут/Т-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2022.02.22 № 119
танай _____-ны № _____-т

БУЙР НУУР-МЭНЭНГИЙН ТАЛЫН
САВ ГАЗРЫН ЗАХИРГААНЫ ДАРГА
Ш.ХАНГАРЬД ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Буйр нуур-Мэнэнгийн талын сав газрын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Буйр нуур-Мэнэнгийн талын сав газрын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.БОЛОРТУУЛ

011020887

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,070,950.00	1,070,950.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	00.00
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	00.00	00.00
31110	Төгрөг	00.00	00.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	00.00
3121	Төгрөг	00.00	00.00
31211	Төрийн сангийн харилцах	00.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	1,070,950.00	1,070,950.00
354	Хангамжийн материал	1,070,950.00	1,070,950.00
35420	Аж ахуйн материал	1,025,950.00	1,025,950.00
35470	Бусад хангамжийн материал	45,000.00	45,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	16,486,421.48	11,607,130.99
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	16,486,421.48	11,607,130.99
392	Биет хөрөнгө	16,332,421.48	11,530,131.03
39203	Авто-тээврийн хэрэгсэл	7,999,500.00	7,659,500.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-97,974.99	-3,339,874.95
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	12,632,720.00	5,895,700.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-8,496,491.27	-1,878,075.00
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	10,995,368.39	10,992,868.39
39208	Хуримтлагдсан элэгдэл	-6,700,700.65	-7,799,987.41
393	Биет бус хөрөнгө	154,000.00	76,999.96
39301	Програм хангамж	154,000.00	154,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-77,000.04
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	17,557,371.48	12,678,080.99
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	17,557,371.48	12,678,080.99
51	Засгийн газрын хувь оролцоо	17,557,371.48	12,678,080.99
512	Хуримтлагдсан үр дүн	17,557,371.48	12,678,080.99
51210	Өмнөх үеийн үр дүн	20,915,393.35	17,557,371.48
51220	Тайлант үеийн үр дүн	-3,358,021.87	-4,879,290.49
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	17,557,371.48	12,678,080.99

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	203,218,786.00	181,607,800.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	11,086,000.00	2,359,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	11,086,000.00	2,359,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	11,086,000.00	2,359,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	11,086,000.00	2,359,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	192,132,786.00	179,248,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	181,872,500.00	179,248,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	181,872,500.00	179,248,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,260,286.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,260,286.00	00.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	206,576,807.87	186,487,090.49
21	УРСГАЛ ЗАРДАЛ	206,576,807.87	186,487,090.49
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	206,576,807.61	183,000,059.49
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	122,609,945.74	117,168,869.00
210101	Үндсэн цалин	83,317,645.74	82,884,669.00
210102	Нэмэгдэл	32,431,600.00	27,423,500.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,860,700.00	6,860,700.00

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,557,800.00	16,557,700.00
210201	Тэтгэврийн даатгал	11,651,700.00	11,651,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,226,500.00	1,226,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	981,300.00	981,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	245,300.00	245,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,453,000.00	2,453,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,502,400.00	19,502,400.00
210304	Байрны түрээс	19,502,400.00	19,502,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	16,222,856.00	5,922,200.00
210401	Бичиг хэрэг	555,800.00	514,200.00
210402	Тээвэр, шатахуун	9,186,536.00	3,213,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,582,492.00	1,260,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	746,800.00	934,400.00
210408	Бараа материал акталсны зардал	4,151,228.00	00.00
2105	Нормативт зардал	00.00	611,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	611,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	156,400.00	2,156,400.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	156,400.00	156,400.00
210604	Урсгал засвар	00.00	2,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	7,927,000.00	2,738,000.00
210702	Дотоод албан томилолт	7,927,000.00	2,738,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,503,520.00	9,619,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,910,200.00	8,910,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	240,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	79,500.00	186,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	74,500.00	73,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	19,800.00	19,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	179,520.00	430,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,096,885.87	8,723,490.49
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,071,750.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	454,042.00	1,485,200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	12,571,093.87	7,238,290.49
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	00.26	3,487,031.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.26	3,487,031.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.26	3,487,031.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-3,358,021.87	-4,879,290.49
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-3,358,021.87	-4,879,290.49

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	20,915,393.35	20,915,393.35
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	20,915,393.35	20,915,393.35
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-3,358,021.87	-3,358,021.87

C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	17,557,371.48	17,557,371.48
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	17,557,371.48	17,557,371.48
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	17,557,371.48	17,557,371.48
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-4,879,290.49	-4,879,290.49
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	12,678,080.99	12,678,080.99

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	192,132,786.00	179,248,800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	192,132,786.00	179,248,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	181,872,500.00	179,248,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	181,872,500.00	179,248,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,260,286.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,260,286.00	00.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	192,132,786.00	179,248,800.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	192,132,786.00	179,248,800.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	192,132,785.74	175,761,769.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	122,609,945.74	117,168,869.00
210101	Үндсэн цалин	83,317,645.74	82,884,669.00
210102	Нэмэгдэл	32,431,600.00	27,423,500.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,860,700.00	6,860,700.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,557,800.00	16,557,700.00
210201	Тэтгэврийн даатгал	11,651,700.00	11,651,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,226,500.00	1,226,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	981,300.00	981,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	245,300.00	245,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,453,000.00	2,453,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,502,400.00	19,502,400.00
210304	Байрны түрээс	19,502,400.00	19,502,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	12,421,628.00	5,922,200.00
210401	Бичиг хэрэг	555,800.00	514,200.00
210402	Тээвэр, шатахуун	9,186,536.00	3,213,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,582,492.00	1,260,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,096,800.00	934,400.00
2105	Нормативт зардал	611,600.00	611,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	611,600.00	611,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	156,400.00	2,156,400.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	156,400.00	156,400.00
210604	Урсгал засвар	00.00	2,000,000.00
2107	Томилот, зочны зардал	7,927,000.00	2,738,000.00

210702	Дотоод албан томилолт	7,927,000.00	2,738,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,503,520.00	9,619,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,910,200.00	8,910,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	240,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	79,500.00	186,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	74,500.00	73,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	19,800.00	19,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	179,520.00	430,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,842,492.00	1,485,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,071,750.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,770,742.00	1,485,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	00.26	3,487,031.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.26	3,487,031.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.26	3,487,031.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	00.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	179,248,800.00	175,761,769.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	179,248,800.00	175,761,769.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	179,248,800.00	175,761,769.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	120,649,800.00	117,168,869.00
210101	Үндсэн цалин	86,365,600.00	82,884,669.00
210102	Нэмэгдэл	27,423,500.00	27,423,500.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,860,700.00	6,860,700.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,557,700.00	16,557,700.00
210201	Тэтгэврийн даатгал	11,651,700.00	11,651,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,226,500.00	1,226,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	981,200.00	981,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	245,300.00	245,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,453,000.00	2,453,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,502,400.00	19,502,400.00
210304	Байрны түрээс	19,502,400.00	19,502,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,922,200.00	5,922,200.00
210401	Бичиг хэрэг	514,200.00	514,200.00
210402	Тээвэр, шатахуун	3,213,300.00	3,213,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,260,300.00	1,260,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	934,400.00	934,400.00
2105	Нормативт зардал	611,600.00	611,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	611,600.00	611,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,156,400.00	2,156,400.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	156,400.00	156,400.00
210604	Урсгал засвар	2,000,000.00	2,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,738,000.00	2,738,000.00
210702	Дотоод албан томилолт	2,738,000.00	2,738,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,625,500.00	9,619,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,910,200.00	8,910,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	186,300.00	186,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	79,200.00	73,100.00

210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	19,800.00	19,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	430,000.00	430,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,485,200.00	1,485,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,485,200.00	1,485,200.00
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	179,248,800.00	175,761,769.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	179,248,800.00	175,761,769.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	179,248,800.00	175,761,769.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	11.00	11.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	8.00	8.00
620003	Үйлчлэх ажилтан	2.00	2.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	00.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	00.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	00.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Буйр нуур – Мэнэнгийн талын сав газрын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Нармандах, аудитор Ч.Удвалноров гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер И.Сэмжидмаа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Болортуул нар тус тус хэрэгжүүлсэн.

Буйр нуур – Мэнэнгийн талын сав газрын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 15 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл нь сав газрын усны нэгдсэн менежментийн төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтэд хяналт тавих, гол мөрөн, нуур усны эх үүсвэр болон орон нутгийн тусгай хамгаалалтад авах үндэслэлийг боловсруулах.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

БОАЖЯ-ны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар эрсдлээс хамаарч 3 жил тутамд хяналт шалгалт хийгдэж байгаа нь дотоод аудитын үр өгөөжийг бууруулж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

БОАЖЯ-ны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас 2019, 2020, 2021 оны 3 дугаар улирлын төсвийн төлөвлөлт болон гүйцэтгэлд цахимаар дотоод аудитыг хэрэгжүүлэн ажилласан байна. Дотоод аудитын хяналт шалгалтаар нийт 7 зөвлөмжийг өгсөн байна. Тухайлбал, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-д “батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох” тухай заалтыг хэрэгжүүлж, цалингийн сангийн тооцооллыг нарийвчлан гаргах, 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” заалтыг хэрэгжүүлж зардлын гүйцэтгэлийг төсвийн зарлагын эдийн засгийн ангиллаар зөв бүртгэж зарцуулах, цаашид харилцагч нэг бүрээр тооцооны данс үүсгэн өглөг, авлагын журналд ажил гүйлгээг бүрэн тусгаж, тооцоо нийлсэн актаар баталгаажуулах зэрэг зөвлөмжийг өгсөн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Буйр нуур – Мэнэнгийн талын сав газрын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 206.6 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 3.1 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувь буюу 2.3 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Бараа материалын дансны үлдэгдэл 1.1 сая төгрөг байна. Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 24.7 сая төгрөг болж 7.1 сая төгрөгөөр буурсан байна. Энэ нь үнэ төлбөргүй хүлээн авсан 2.3 сая төгрөгийн хөрөнгөөр нэмэгдэж, үндсэн хөрөнгийн үнийг

шинэчлэн тогтоосны зөрүү 7.9 сая төгрөг, хөрөнгийг акталж данснаас хассан 1.5 сая төгрөг зэргээс шалтгаалсан байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 21.6 сая төгрөгөөр буурсан байна. Тайлант онд нэмэлт санхүүжилтийн орлого орж ирээгүй болон үнэ төлбөргүй хүлээн авсан орлого өмнөх оноос 8.7 сая төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 20.1 сая төгрөгөөр буурсан нь хангамж, бараа материалын зардал, үндсэн хөрөнгийн элэгдэл, цалингийн зардал зэрэгтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 179.2 сая төгрөгөөр, нийт зарлагыг 179.2 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 179.2 сая төгрөгийн төсөв баталснаас 179.2 сая төгрөгийг улсын төсвөөс бүрэн баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 98.1 хувь буюу 175.7 сая төгрөг, буцаан төвлөрүүлсэн 1.9 хувь буюу 3.5 сая төгрөг байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд нэмэлт санхүүжилтийн дансаар гүйлгээ хийгдээгүй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ, үйл явдал гараагүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Буйр нуур-Мэнэнгийн талын сав газрын захиргаа нь 2021 онд нийт 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас хуулийн хугацаанд бүрэн мэдээлсэн байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2.8 сая төгрөгийн төлбөрийн акт, 7.5 сая төгрөгийн албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар захиргааны хэм хэмжээгээр тогтоосон тогтоол, журмуудыг мөрдөж ажиллаж байгаа эсэхийг анхаарч үзэх.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 6.7 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 3.3 сая төгрөгийн алдааг завсрын аудитаар залруулан, 3.4 сая төгрөгийн зөрчилд зөрчил арилгах 3 албан шаардлага хүргүүлсэн.

4.1 Залруулсан алдаа

Тайлант хугацаанд завсрын аудитаар 3.3 сая төгрөгийн алдааг залруулсан.

4.2 Төлбөрийн акт

Тайлант хугацаанд төлбөрийн акт тогтоогдоогүй болно.

4.3 Албан шаардлага

1. Тээвэр шатахууны зардлаас коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлын үед Зүүн бүсийн сургалтад оролцон 0.6 сая төгрөг, Засгийн газрын 43 дугаар тогтоолын 1.5-д “салбарын хэмжээнд хийх сургалт, семинар, хурал, зөвлөгөөн болон газар дээрх хяналт-шалгалт зэргийг цахим хэлбэрээр зохион байгуулж, сургалт, семинар, хурал, зөвлөгөөн зэрэг арга хэмжээний болон дотоод албан томилолтын зардлыг хэмнэх;” гэж заасныг зөрчсөн байна.

2. Тээвэр шатахууны зардлаас газар дээрх хяналт-шалгалт хийн 1.3 сая төгрөгийг зарцуулсан ажлын төлөвлөгөө, тайлан болон бусад баримтуудаар нотлогдохгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” гэснийг зөрчсөн, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3. Коронавируст халдвар(Ковид-19)-ын цар тахлын үед Туул голын сав газрын захиргаанд туршлага судлан 1.4 сая төгрөгийн зардал гаргасан нь Засгийн газрын 43 дугаар тогтоолын 1.5-д “салбарын хэмжээнд хийх сургалт, семинар, хурал, зөвлөгөөн болон газар дээрх хяналт-шалгалт зэргийг цахим хэлбэрээр зохион байгуулж, сургалт, семинар, хурал, зөвлөгөөн зэрэг арга хэмжээний болон дотоод албан томилолтын зардлыг хэмнэх” гэснийг зөрчсөн байна.

4.4 Зөвлөмж

Тайлант хугацаанд зөвлөмж өгөгдөөгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Буйр нуур-Мэнэнгийн талын сав газрын захиргаа	4	6.7	1	3.4	-	-	3	3.3	-	-